Российская академия наук
Институт восточных рукописей
(Азиатский Музей)

Адрес учредителя: 191181,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Адрес редакции: 191181,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Адрес издателя: 191181,
Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Тел.: +7 (812) 315-87-28
http://orientalstudies.ru
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

Регистрационный номер
свидетельства о регистрации
средства массовой информации
ПИ No ФС77-79202
от 22 сентября 2020 г.

MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведных исследований

Том XXVIII • 2025 • № 4

Выходит 4 раза в год
Издается с 1986 г.
Учредитель: ФГБУН
Институт восточных рукописей РАН

Редакционная коллегия:

И. В. Кульганек, *главный редактор, доктор филологических наук (Россия)*
Д. А. Носов, *секретарь редколлегии, кандидат филологических наук (Россия)*
М. А. Козинцев, *помощник секретаря, кандидат исторических наук (Россия)*

Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*
А. Бирталан, *доктор наук (Венгрия)*
Р. М. Валеев, *доктор исторических наук (Россия)*
Л. С. Дампилова, *доктор филологических наук (Россия)*
И. В. Зайцев, *доктор исторических наук, профессор РАН (Россия)*
Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*
В. Капишовска, *доктор наук (Чехия)*
Э. Мунхцэцэг, *кандидат филологических наук (Монголия)*
С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*
К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*
М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*
Р. Поп, *доктор наук (Румыния)*
Ц. Саранцацрал, *доктор филологических наук (Монголия)*
Т. Д. Скрынникова, *доктор исторических наук, профессор (Россия)*
С. Чулуун, *академик МАН (Монголия)*
Е. Э. Хабунова, *доктор филологических наук (Россия)*
Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*
Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*

Оригинал-макет – М. В. Алексеева
Литературные редакторы и корректоры – Д. А. Носов, И. В. Кульганек
Технический редактор – М. А. Козинцев
Подписано в печать 15.12.2025
Формат 60×90 $^{1}/_{8}$. Объем 9 печ. л. Заказ №
Тираж 300 экз.
Отпечатано в типографии ООО «Литография Принт».
Адрес типографии: 191119, Санкт-Петербург, ул. Днепропетровская, д. 8, лит. А, офис 14.
e-mail: info@litobook.ru

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/zk3g-736z-g9nu

12+

© Институт восточных рукописей РАН (Азиатский Музей), 2025
© Коллектив авторов, 2025

В НОМЕРЕ:

ФИЛОЛОГИЯ

Б. Мөнх-Эрдэнэ. Д. Цоодолын уран бүтээлийн өв, туурвилын онцлог 5

М. В. Фионин. Маргарита Михайловна Елизарова как переводчик Апокрифа завещание Авраама: вклад в изучение древнееврейских текстов..... 13

С. Энхжаргал. Монгол хэлний хэлцэд оршихуйн зүйрлэл илрэх нь 25

СМЕЖНЫЕ ДИСЦИПЛИНЫ

И. А. Алимов. «Дун цзин мэн хуа лу»: великие внутренние [покои] 33

К. А. Бекетов, Н. К. Бекетова, Ли Чжуанчжи. Анализ поступательного развития российско-китайского сотрудничества в художественной сфере 41

Е. М. Белкина. Еврейская палеография в Иране: от первых документов до XIV в. 53

НАУЧНАЯ ЖИЗНЬ

Л. С. Дампилова. III Сибирский форум фольклористов. Международная научная конференция (Новосибирск, 16–20 июня 2025 г.) 64

Т. В. Ермакова. Конференция «Актуальные проблемы буддологических и индологических исследований–19» (Санкт-Петербург, 14 июля 2025 г.) 67

Р. В. Ивлева. Международный симпозиум по монголоведению 2025 (Китай, Хух-Хото, 20–21 августа 2025 г.) 70

Н. В. Ямпольская. Выставка «Калмыцкие буддийские шедевры из музеев Санкт-Петербурга» в Национальном музее республики Калмыкия им. Н. Н. Пальмова (Элиста, 25 сентября — 16 ноября 2025 г.) 76

РЕЦЕНЗИИ

Е. В. Асалханова. *Рец. на*: Батырева С. Г. Живопись во времени и пространстве культуры. К 100-Летию Народного Художника РСФСР Гаря Рокчинского (1923–1993) 80

М. П. Петрова. *Рец. на*: Эх орон-Их Ялалт. Родина-Великая Победа 86

RUSSIAN ACADEMY OF SCIENCES
Institute of Oriental Manuscripts
(Asiatic Museum)

MONGOLICA

Saint Petersburg journal for Mongolian studies

Vol. XXVIII • 2025 • No. 4

The journal is published four times a year.
Published since 1986
Founder: Federal State Institution of Science
Institute of Oriental Manuscripts of the Russian Academy
of Sciences

Editorial board:

I. V. Kulganek — *editor-in-chief, Dr. Sci. (Philology), Russian Federation*
D. A. Nosov — *secretary, Cand. Sci. (Philology), Russian Federation*
M. A. Kozintcev — *assistant secretary, Cand. Sci. (History), Russian Federation*

G. Bilguudei. *Dr. Sci. (Philology), Mongolia*
A. Birtalan. *Ph. D., Hungary*
S. Chuluun. *Academician of the Mongolian Academy of Sciences, Mongolia*
L. S. Dampilova. *Dr. Sci. (Philology), Russian Federation*
J. Legrand. *Dr. Sci., Professor, France*
V. Kapishovska. *Ph. D., Czech Republic*
E. E. Khabunova, *Dr. Sci. (Philology), Russian Federation*
N. Khishigt. *Ph. D. (History), Mongolia*
E. Munkhtsetseg. *Cand. Sci. (Philology), Mongolia*
S. L. Neveleva. *Dr. Sci. (Philology), Russian Federation*
K. V. Orlova. *Dr. Sci. (History), Russian Federation*
M. P. Petrova. *Ph. D. (Philology), Russian Federation*
R. Pop. *Ph. D., Romania*
Ts. Sarantsatsral. *Dr. Sci. (Philology) Mongolia*
T. D. Skrynnikova. *Dr. Sci. (History), Russian Federation*
R. M. Valeev. *Dr. Sci. (History), Russian Federation*
N. S. Yakhontova. *Cand. Sci. (Philology), Russian Federation*
I. V. Zaytsev. *Dr. Sci. (History), Professor of the Russian Academy of Sciences, Russian Federation*

191181. Russian Federation
Saint Petersburg,
Dvortsovaya Emb., 18

Phone: +7 (812) 315-87-28
http://orientalstudies.ru
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/zk3g-736z-g9nu

© Institute of Oriental Manuscripts RAS
(Asiatic Museum), 2025
© Group of authors, 2025

IN THIS ISSUE:

PHILOLOGY

Batmunkh Munkh-Erdene. The Artistic Heritage and Stylistic Features of D. Tsoodol's Works 5

Maksim V. Fionin. Margarita Mikhailovna Elizarova as a Translator of the Apocryphal "Testament of Abraham": On Her Contribution to the Study of Ancient Hebrew Texts 13

Sanjperleegiin Enkhjargal. The Manifestation of Ontological Metaphor in Mongolian Idioms..... 25

RELATED DISCIPLINES

Igor A. Alimov. «Dong Jing Meng Hua Lu»: Great Inner [Chambers] 33

Konstantin A. Beketov, Natalya K. Beketova, Li Zhuangzhi. Tanalysis of the Progressive Development of Russian-Chinese Cooperation in the Field of Fine Arts 41

Ekaterina M. Belkina. Hebrew Palaeography in Iran: From Early Documents to the Manuscripts of the 14th Century 53

ACADEMIC LIFE

Lyudmila S. Dampilova. The 3rd Siberian Forum of Folklore Researchers. International Scientific Conference (Novosibirsk, June 16–20, 2025) 64

Tatiana V. Ermakova. The 19th Conference "Current Issues of Bbuddhological and Indological Studies" (St. Petersburg, July 14, 2025) 67

Regina V. Ivleva. The International Symposium on Mongolian Studies 2025 (Hohhot, China, August 20–21, 2025) 70

Natalia V. Yampolskaya. "Kalmyk Buddhist Masterpieces From The Museums of St. Petersburg" — an Exhibition at the National Museum of the Republic of Kalmykia (Elista, September 25 — November 16, 2025)..... 76

BOOK REVIEWS

Ekaterina V. Asankhanova. *Rev. of the book*: Batyreva, Svetlana. G. Painting in Time and Space of Culture. To the 100th Birthday Anniversary of the People's Artist of the Russian Soviet Federative Socialist Republic Garya Rokchinsky (1923–1993)..... 80

Maria P. Petrova. *Rev. of the book*: Motherland — Great Victory..... 86

УДК 81.13
DOI 10.48612/IVRRAN/2rpt-3r7z-zg75

С. Энхжаргал
Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэн

МОНГОЛ ХЭЛНИЙ ХЭЛЦЭД ОРШИХУЙН ЗҮЙРЛЭЛ ИЛРЭХ НЬ

Хэл бол хүний сэтгэлгээний тусгал, танин мэдэхүйн бүтэц бөгөөд орчин үеийн хэл шинжлэлийн судалгаанд аливаа хэлний хэлц нэгжийг танин мэдэхүйн үүднээс шинжлэх нь түгээмэл хандлага болж байна. Хэлц нь тухайн ард түмний ертөнцийг үзэх үзэл, сэтгэлгээний хэв маягийг илэрхийлдэг бөгөөд хийсвэр ойлголтыг бодит, мэдрэгдэхүйц туршлагаар дамжуулан илтгэдэг хэлний өвөрмөц нэгж юм. Хэлцийн шилжсэн утгын бүтцийн гол үндэс нь метафор буюу зүйрлэл бөгөөд энэ нь танин мэдэхүйн гүн бүтэцтэй салшгүй холбоотой.Танин мэдэхүйн хэл шинжлэлийн онолд "сав" зүйрлэл (container metaphor) нь хүний биеийн туршлага, орон зайн мэдрэмжид тулгуурласан нийтлэг сэтгэлгээний загвар гэж үздэг. Энэхүү өгүүлэлд монгол хэлний хэлц үгсэд илэрч буй "сав" зүйрлэлийн илрэл, бүтэц, утга зүйн онцлогийг Ж. Лакофф, М. Жонсон нарын зүйрлэлийн онолын хүрээнд задлан шинжилж, англи хэлний ижил төрлийн хэлцтэй харьцуулсан болно. Судалгааны үр дүнд монголчуудын сэтгэлгээ нь бүхэллэг, нэгдмэл, орон зайн ухагдахуунаар ертөнцийг ойлгох хандлагатай болох нь тодорхой болов.

Түлхүүр үг: хэлц, онтологи, оршихуйн зүйрлэл, сав зүйрлэл, монгол сэтгэлгээ.

Зохиогчийн тухай: Санжпэрлээгийн Энхжаргал (Ph. D.), Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн Дуун ухааны сан хөмрөгийн эрхлэгч (Улаанбаатар, Монгол Улс) (enkhjargals@mas.ac.mn).

© Энхжаргал С., 2025

Хүн ба бусад оршихуйн эд юмсын хооронд харилцан уялдаа холбоо бий болсноор хүн, байгаль, нийгмийн юмс үзэгдлээр дамжуулан аливаа ухагдахууныг хялбар ойлгох боломж бүрддэг. Тэрхүү ойлгож ухаарах үйл явц хэлээр хэрхэн илэрч буйг танин мэдэхүйн хэл шинжлэлийн зүйрлэлийн онолын хүрээнд тайлбарлах нь монгол хэл шинжлэлийн судалгаанд сүүлийн жилүүдэд эрчимжиж байна.

Танин мэдэхүйн зүйрлэлийн онолын судалгааг анх Жорж Лакофф, Марк Жонсон нарын "Metaphors we live by" /1980/ хэмээх бүтээлд цогц байдлаар гаргаж тавьсан гэж үздэг. Мөн "The Contemporary Theory of Metaphor" /1993/ гэсэн бүтээлдээ "зүйрлэлийн мөн чанар нь хэлэнд бус оюун санаанд оршдог" хэмээн зүйрлэлийг хэлний бус сэтгэхүйн хэлбэр гэж үзсэн нь бий. "Хүн нийгмийн оюун санаанд хуримтлагдсан туршлага, танин мэдэхүйн сэрэл, мэдрэхүйн талыг түлхүү барьж томьёолсон бөгөөд хүн харилцаандаа зүйрлэл хэрэглэх, хүний зүйрлэх сэтгэлгээний үндсийг үндэсний хэлтэй нь биш, сэтгэлгээнийх нь хэв шинж, соёл-сэтгэлгээтэй нь илүүтэй холбож үзсэн" [Магсар, 2012. С. 59] байдаг.

Тодорхой үндэстэн угсаатны тухайд тэдний уламжлалт оюуны соёлын мөн чанар нь тэдний сэтгэлгээний тогтвортой хэв шинж болдог [Ж. Баянсан, 2016. С. 37] гэж үзэх бөгөөд үндэсний сэтгэлгээний онцлогийг тайлбарлахын тулд танин мэдэхүйн хэл шинжлэлийн өнөөгийн чиг хандлага болж буй Ж. Лакофф, М. Жонсон нарын танин мэдэхүйн зүйрлэл (cognitive conceptual metaphor)–ийн онол бидний судалгааны гол чиг баримжаа болж байна.

Ж. Лакофф ба М. Жонсон нарын "Metaphors We Live By" (1980) бүтээлд танин мэдэхүйн зүйрлэлийг гурван үндсэн төрөлд ангилсан. Эдгээр нь:

1. Баримжааны зүйрлэл (Orientational Metaphor),
2. Оршихуйн зүйрлэл (Ontological Metaphor),
3. Бүтцийн зүйрлэл (Structural Metaphor)

юм. Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1

Төрөл	Тодорхойлолт	Монгол хэлний жишээ	Концептуал схем
Баримжааны зүйрлэл	Эд зүйлс, аливаа ойлголтыг орон зайн чиглэлээр (дээш, доош, дотор, гадна гэх мэт) ойлгуулдаг.	амжилт өсөх (амжилт=дээш) нэр хүнд унах (нэр хүнд=доош)	АМЖИЛТ ДЭЭШ БАЙДАГ – НЭР ХҮНД ДООШ МУУДАХ
Оршихуйн зүйрлэл	Хийсвэр ойлголтыг бодит биет мэтээр ойлгуулдаг.	Цаг хугацаа ирнэ (цаг хугацаа=зүйрлэсэн обьект), Сэтгэлээ хураах (сэтгэл=сав)	ХИЙСВЭР ОЙЛГОЛТ = ОБЬЕКТ / САВ
Бүтцийн зүйрлэл	Нэг ойлголтын бүтэц, тогтолцоог нөгөөгөөр тайлбарлах.	Амьдрал бол аялал (зорилго, саад, зам), Маргаан бол дайн (тэмцэл, ялалт, ялагдал)	АМЬДРАЛ = АЯЛАЛ МАРГААН = ДАЙН

Жорж Лакофф (George Lakoff) болон **Марк Джонсон (Mark Johnson)** нар **"Metaphors We Live By"** бүтээлдээ оршихуйн зүйрлэлийг танин мэдэхүйн зүйрлэлийн үндсэн төрөл хэмээн тодорхойлж хүний танин мэдэхүйд гүн суусан ойлголтуудыг бүтэцжүүлж, дэлгэрэнгүй тайлбарлахад уг онолыг ашигладаг гэж үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтөн аливаа хийсвэр ойлголт, аливаа туршлагыг **бие даасан, бодит объект** мэт ойлгож, ярьдаг сэтгэлгээний загвар бөгөөд хүний **танин мэдэхүйн үйл явц** дахь нэг чухал үйл ажиллагаа юм. Ингэснээр бид хийсвэр үзэгдлийг **"хүрэх, барих, хэмжих, дотор нь байх"** гэх мэт физик үйлдлээр дүрсэлж чаддаг бөгөөд бидний хэл ярианд тогтмол хэрэглэгдэж байдаг.

"Онтологи" гэдэг нь философийн шинжлэх ухаанд **оршихуйн мөн чанар, зүйлсийн төрөл, тэдгээрийн ангилал**-ыг судлах утга агуулгатай нэр томьёо юм. Тиймээс монгол хэл шинжлэлийн хүрээнд оршихуй гэсэн үгээр орчуулан хэрэглээд нэгэнт хэвшиж байна.

Монгол хэлэнд онтологи буюу оршихуйн зүйрлэл (ontological metaphor) өргөн хэрэглэгддэг бөгөөд энэ нь соёл, уламжлал, байгаль орчны онцлогтой нягт холбоотой байдаг. Оршихуйн зүйрлэлийг хэрэглэснээр яриаг илүү дүрслэлтэй, сэтгэл хөдлөм болгодог байна. Амьдралын болоод бие махбодын туршлагаараа дамжуулан аливаа үйл явдал, үйлдэл, сэтгэл хөдлөл, санаа гэх мэт хийсвэр үзэгдлийг юм, бодис гэж хүлээж авдаг оршихуйн зүйрлэлийн хэлбэр монгол хэлнээ хэрхэн үүсэж байгаа нь монгол хэл шинжлэлд сонирхолтой асуудал юм.

Бид монгол хэлний баримтад оршихуйн зүйрлэл хэрхэн илэрч буйг судалснаар:

- Бичгийн хэл ба ярианы хэлний бүтцийг гүнзгийрүүлэн судлах.
- Ярианы далд утга, сэтгэл хөдлөлийг тайлбарлах.
- Хиймэл оюун ухаан, хэлний боловсруулалтад хэрэглэж, танин мэдэхүйн ойлголтыг бүтцээр илэрхийлэх.
- Соёл хоорондын харилцаанд үгийн утга, хэлц хэллэгийн ялгааг тайлбарлах зэрэг онол болоод хэрэглээний ач холбогдолтой гэж үзэж болно.

Ж. Лакофф, М. Жонсон нарын дэвшүүлснээр оршихуйн зүйрлэлийн хэд хэдэн төрөл байна. Үүнд:

1. Хийсвэр зүйлсийг бие даасан объект мэт ойлгох (**Объект)**: сэтгэл алдрах, сэтгэлийн жолоо алдах ("I lost my mind", "Catch the idea")

2. Оршихуй, ойлголтыг дотор/гадна гэж дүрсэлж ойлгох **(Container)**: айдаст автах (айдас дотор орох), сэтгэлдээ нуух ("In fear", "Keep it in mind")

3. Чанар, мэдрэмжийг бодис мэт ойлгох **(Substance)**: хайраар дүүрэн, буян нь цалгих ("Full of love", "Rich in kindness")

4. Ямар нэг цогц зүйлийг хэсэг болгон төсөөлөх **(Part-Whole)**: өөрийн дотоод ертөнц, нийгмийн хэсэг ("Part of society", "Inner world")

5. Хийсвэр ойлголтод хүний зан шинж өгөх **(Personification)**: аз жаргал ирлээ, боломж хаалгыг минь тогшив ("Luck came", "Opportunity knocks")

Дээрх ангиллаас олонх эрдэмтэн, судлаач "сав" гэх зүйрлэлийг онцгойлон үзсэн байдаг нь бидний судалгааны гол үндэслэл болно. "Сав" зүйрлэл (container metaphor) нь санаа, бодол хэлний тодорхой нэгжийг "сав дүүргэж" байгаа юм шиг дүүргэдэг гэж төсөөлдөг бөгөөд ихэвчлэн хүн өөрийн доторх сэтгэл, бодол, мэдрэмжээ эсвэл мэдлэгээ тодорхой "сав" дотор хадгалж буй мэтээр ойлгож, хэлээр илэрхийлдэг гэсэн санаа юм. Сав зүйрлэл нь аливаа ойлголт, мэдрэмж, санааг "хадгалдаг" эсвэл "дүүргэдэг" гэж ойлгоход хэрэглэгддэг бөгөөд хүмүүсийн сэтгэл зүй, оюун санааг илэрхийлэх хийсвэр сэтгэлгээний чадвартай холбоотой. Энэхүү зүйрлэлийн хэлбэрийг судалснаар монгол хүний оршихуйн дотоод ертөнцийг олон янзаар илэрхийлэх, ойлгуулах, тайлбарлах монгол хэлний хэрэглээний онцлогийг илрүүлэх боломжтой.

Аливаа оршихуй, хийсвэр ойлголтыг дотор/гадна **(container)** гэж дүрсэлж ойлгох тухай хэл шинжлэлийн онолын үндэслэлийг дараах байдлаар товч тодорхойлж болно. Үүнд:

1. Хийсвэр ойлголтыг биет орон зайгаар төсөөлөх:

Хүний оюун ухаан хийсвэр сэтгэл зүйн ойлголтыг ойлгоход бие махбодын туршлага, орон зайтай холбоотой танин мэдэхүйн схем, загварыг ашигладаг. Тухайлбал, сэтгэл, бодол, мэдрэмж гэх мэт хийсвэр ойлголтыг бид сав буюу контейнер шиг хязгаарлагдсан орон зай гэж төсөөлдөг.

2. Савны бүтэцтэй танин мэдэхүйн схем.

Сав гэж зүйрлэх нь "дотор", "гадаа", "хязгаар", "дүүрэх", "хоосрох", "хальж урсах", "түгжих", "онгойх" зэрэг орон зайн болон үйлдлийн ойлголтыг багтаадаг. Энэхүү савны бүтэц нь танин мэдэхүйн нийтлэг схем бөгөөд олон хэлний хэллэг, хэлц үг, илэрхийллүүдэд тусгалаа олдог.

3. Зүйрлэл нь сэтгэл зүй, хэлний харилцаанд суурь үүрэгтэй.

Сав зүйрлэл нь хүний сэтгэл зүйн төлөв байдал, мэдрэмжийн хөдөлгөөн, бодол санааны хязгаарлалтыг дүрслэхэд ашиглагдаж, хэл ярианы бүтэц, хэллэгт гүнзгий нөлөө үзүүлдэг.

4. **Соёл, хэлний ялгааг даван туулсан танин мэдэхүйн загвар.**

Сав зүйрлэл нь олон хэл, соёлд давтагддаг танин мэдэхүйн схем, загвар бөгөөд хэлний онцлог, хэлц үгийн бүтэц, уран сайхны илэрхийлэл зэрэгт өөр өөр хэлбэрээр оршдог.

Дээрхээс үзвэл: сав зүйрлэл нь хүн, оюун санаан дахь хийсвэр ойлголтуудаа сав мэт орон зайгаар төсөөлж, сэтгэл, бодол, мэдрэмжийн хөдөлгөөн, хэмжээ зэргийг савны багтаамж, дүүрэлт, хязгаарлалт гэх мэтээр дүрслэн тайлбарлах танин мэдэхүйн хэлний арга юм. Өөрөөр хэлбэл, сав зүйрлэл нь нарийн төвөгтэй санааг биетэй, бодтой сав буюу агуулдаг юмтай зүйрлэн ойлгох, дамжуулахад хэрэглэдэг үндсэн хэрэгсэл юм. Ингэснээр хийсвэр эсвэл биет бус ойлголтуудыг, бусад элементүүдийг агуулсан, хавсаргасан эсвэл агуулж буй объект мэт сэтгэж, ойлгоход хялбар дөхөм болгодог.

Сав зүйрлэл бидний хэл ярианд өргөн хэрэглэгддэг хэдий ч ихэнхдээ анзаарагддаггүй. Тухайлбал: *дотор онгойх, дотор бачуурах, сэтгэл үймрэх, сэтгэлд багтах, санаанд орох, санаанаас гарахгүй байх, сэтгэлдээ хадгалах, сэтгэлээ уудлах, сэтгэл дүүрэх, айдсаас мултрах, айдаст автах* гэх мэт. Эдгээр зүйрлэл нь бидний сэтгэл хөдлөлийн болон сэтгэцийн төлөв байдлын талаарх ойлголтыг ямар нэг орон зайд агуулагдаж байгаа гэж үзэх бөгөөд хүний амьдралын явцад хэрхэн харилцах, ойлголцох зэрэгт шууд нөлөөлдөг.

Монгол хэлний хэлц дэх зүйрлэлийн онцлогийг тодруулан шинжлэхийн тулд англи хэлний **сав зүйрлэлээр илрэх хэлцтэй харьцуулж үзвэл бидний судалгаа илүү тодорхой, үр дүнтэй болно гэж үзлээ. Үүний тулд монгол, англи хэлний хэлц үгсийг 1. хайр, уур, гуниг, айдас зэрэг хийсвэр ойлголтыг сэдэвчлэн; 2. сэтгэл хөдлөлийн эерэг, сөрөг үнэлэмжээр тодорхойлж; 3. ямар сав, ямар үйлдэл оролцож байгаа бүтцийн талаас тус тус харьцуулах боломжтой юм. Хүснэгтээр үзүүлбэл:**

Хүснэгтээс ажиглахад **монгол хэлц үгсэд б**айгалийн уран дүрслэл давамгайлж, ёс суртахуун, уламжлалт үнэт зүйлсийн тухай илэрхийлэл илүү олон байхын дээр хэмжээний хувьд богино, хэлэхэд эвтэй сонсголонтой, үндэсний соёлын гүн гүнзгий утга агуулгатай байхад

Хүснэгт 2

Сэдэв	Хэл	Хэлц үг	Сэтгэл хөдлөл	Сав зүйрлэлийн бүтэц
хайр	монгол	сэтгэлдээ тээх	эерэг/нууц	сэтгэл = тээврийн сав (зүйлийг хадгалах)
	англи	I'm in love	эерэг	хайр = орон зай, би дотор нь байна
уур	монгол	уур нь багтаж ядах	сөрөг	уур = дотор нь багтахгүй их зүйл
	монгол	дотроо буцлах	сөрөг/нууц	сэтгэл = буцалж буй шингэнтэй сав
	англи	He's full of anger	сөрөг	бие = уураар дүүрсэн сав
	англи	She bottled up her anger	сөрөг/нууц	эмоци = лонхонд хийж тагласан зүйл
гуниг	монгол	сэтгэл нь хөндүүрлэх	сөрөг	сэтгэл = эмзэг сав, гаднаас нөлөө авдаг
	монгол	шархтай зүрх	сөрөг	зүрх = шархалсан сав мэт ойлгогдож байна
	англи	Her heart is broken	сөрөг	heart = хагарсан сав
айдас	англи	Fear gripped him	сөрөг	бие = сав, гадаад хүч түүнийг дүүргэж, эзэлж байна
	монгол	сэтгэл зовних	сөрөг/эмзэг	сэтгэл = тогтворгүй, сав мэт ойлгогдож байна
баяр	монгол	сэтгэл дүүрэн	эерэг	сэтгэл = баяраар дүүрсэн сав
	англи	My heart is full of joy	эерэг	зүрх = баяраар дүүрсэн сав
	англи	Bursting with excitement	эерэг	бие = хэт их баяраар "дүүрч" дэлбэрэх гэж буй сав

англи хэлний хэлцэд орчин үеийн өгүүлэмж, агуулга давамгайлж, ойлгоход хялбар дөхөм, энгийн буюу уран дүрслэл бага, харин шоглосон егөөдсөн өнгө аястай, хэмжээний хувьд урт өгүүлбэртэй, олон соёлын орчинд ойлгогдохуйц өргөн хэрэглээний үгсээс бүтсэн, шилжсэн утга харьцангуй багатай зэрэг хэлбэр, бүтэц, утга, агуулгын ялгаа илэрч байна. Ижил ба ялгаатай шинжийг харьцуулбал:

- **Монгол хэлэнд** сэтгэл, зүрх, дотор зэрэг **хүний дотоод орон зайг** сав мэтээр дүрсэлдэг.
- **Англи хэлэнд** emotion, heart, mind зэрэг хийсвэр ойлголтуудыг **тодорхой "объект" буюу лонх, сав, орон зай** хэлбэрээр төсөөлдөг.

Харин хоёр хэлний хэлц үгсэд **нууцлаг, дотогшоо сэтгэл хөдлөлийг** ихэвчлэн **"хадгалах, тээх, багтаах"** үйл үгсээр илэрхийлдэг. **Хэт их сэтгэл хөдлөлийг** "**дүүрэх, дэлбэрэх, гаргах**" зэрэг үйл үгтэй хамт хэрэглэж, савны багтаамжаас давсан мэт илэрхийлдгээрээ ижил төстэй байна. Энэ нь нийт хүн төрөлхтний танин мэдэхүйн сэрэл, мэдрэмжийн үйл ажиллагаатай холбоотой гэж болно.

Монгол хэлний оршихуйн зүйрлэлийн нэг хэлбэр болох сав багтаамжийн зүйрлэлийг илүү тодруулахын тулд монгол хэлний "сэтгэл" гэх хийсвэр ойлголтыг онцлон авч үзвэл илүү үр дүнтэй байна. Учир нь монгол хэлний хэлцийн жишээ, баримтад **сэтгэл** гэх хийсвэр ойлголтыг оршихуйн зүйрлэлээр илэрхийлэх нь хамгийн их давтамжтай байх бөгөөд энэ талаар эрдэмтдийн судалгаа ч олон бий.

Танин мэдэхүйн хэл шинжлэлд үг, хэллэг нь дан ганц хэлний хэлбэр бус, тухайн соёлын сэтгэлгээний системийн тусгал гэж үздэг [Langacker, 1987; Evans & Green, 2006]. "Сэтгэл" гэх үг монгол хэлний хэрэглээнд монгол хүний дотоод ертөнцийн хандлага, сэтгэлийн хөдөлгөөний илэрхийлэл, хүний ёс суртахуун, зан үйлийг тусгана. Монголчуудын хувьд энэхүү сэтгэл гэх хийсвэр зүйлийг өөрийнхөө хийсвэр эрхтэн хэмээн сэтгэж, **сэтгэлд бүх зүйл агуулагдаж, сэтгэлээс бүх зүйл төрнө** гэсэн үзэл хандлагатай байдаг. Бид "сэтгэл" гэх үг орсон монгол хэлний 100 орчим хэлцийг "Монгол хэлний их тайлбар толь" https://mongoltoli.

№	Зүйрлэлийн хэлбэр	Хэлцийн жишээ	Танин мэдэхүйн утга
1	СЭТГЭЛ БОЛ САВ	Сэтгэл онгойх, сэтгэл дүүрэх, сэтгэл хоосрох	Сэтгэл нь зүйлсийг “агуулах”, “гаргах” орон зай мэт ойлгогдоно
2	СЭТГЭЛ БОЛ ГАЛ/ ДУЛААН	Сэтгэл халуун, сэтгэл хөрөх, сэтгэл шатах	Сэтгэлийн хөдөлгөөн, эрч хүчийг дулаан, галтай зүйрлэнэ
3	СЭТГЭЛ БОЛ ШИНГЭН ЗҮЙЛ	Сэтгэл урсах, сэтгэл уужрах	Сэтгэл нь урсгалтай, хэлбэлзэлтэй зүйл гэж ойлгогдоно
4	СЭТГЭЛ БОЛ АМЬД БИЕ	Сэтгэл өвдөх, сэтгэл унах, сэтгэл үхэх	Сэтгэлийг амьд амьтантай адил “зовох”, “амьдрах” зүйл гэж үзнэ
5	СЭТГЭЛ БОЛ ХҮНИЙ ГОЛ МӨН ЧАНАР	Сэтгэл сайхан хүн, сэтгэлгүй амьтан	Ёс суртахуун, хүн чанарын хэмжүүр

mn/dictionary/detail/-ооc түүвэрлэн ажиглаж судалгаандаа ашиглав. Уг цахим толь бичигт “сэтгэл” гэсэн толгой үгийн хүрээнд нийт 160 хэллэг байгаагаас 93 хэлц, 41 нийлэмж үг, 26 холбоо үг бөгөөд 60 орчим хувь нь дан хэлц үг байгаа нь бидний судалгааны зорилгыг улам тодорхой болгов. Өөрөөр хэлбэл, монгол хэлний үгийн санд “сэтгэл”-ийн тухай илэрхийлэл ийм олон байгаа нь монгол хүний сэтгэлгээний гол төв нь “сэтгэл” хэмээх танин мэдэхүйн концепт болж, түүгээр сэтгэлийн хөдөлгөөн, ёс суртахуун, хайр, итгэл, зовлон, хүч чадал зэрэг өргөн хүрээний хийсвэр ойлголтыг илэрхийлж байдаг ажээ. Эдгээр хэлцийн жишээнээс багцлан Ж. Лакофф, М. Жонсон нарын онолын загварт оруулбал дараах хэлбэртэй байна.

Эдгээр зүйрлэл нь монголчуудын хувьд “сэтгэл”-ийг материаллаг, хөдөлгөөнтэй, дулаантай, амьд зүйл мэтээр төсөөлдгийг илтгэнэ. Сав багтаамжийн зүйрлэлийн үүднээс загварт оруулбал:

[СЭТГЭЛ] — ойлголтын хүрээ (оршихуйн төсөөлөл) — [ХАЙРЦАГ/САВ]

↓

сэтгэлд орсон зүйл: *хайр, айдас, баяр*
сэтгэлээс гаргах зүйл: *гуниг, уур*
сэтгэлийг дүүргэх зүйл: *баяр, хайр*
сэтгэл хоосрох үед: *уйтгар, гуниг*

Сэтгэл гэх хийсвэр эрхтний нэрийг зүрх гэсэн булчинлаг бодит эрхтэнтэйгээ холбож “сэтгэл зүрх” гэсэн нийлц монгол хэлний хэлцийн санд илэрдэг. Жишээ нь: **зүрх дэлбэрэх** (үнхэлцэг хагарах), **зүрх маажих** (сэтгэлийг уяруулан догдлуулах, сэтгэлийг хөдөлгөх, **зүрх түгших** (сэтгэл санаа тавгүйтэх), **зүрхэнд хүрэх** (бялуурах, шандуурах), **уушги зүрх амаар гарах шахах** (а. Айж цочих; б. Ихэд аахилан амьсгаадах; в. Хэт цухалдах), **уушги зүрх сагсайх** (ихэд уурлах, бачимдах), **элэг зүрх өмрөх** (санаа сэтгэл зовж ихэд шаналах), **зүрх алдах** (айж төвөгшөөх), **зүрх гаргах** (аливаа үйлд зориг гаргах), **зүрх мохох** (зориг самбаа харих), **зүрх орох** (зоригтой болох), **зүрх өвдөх** (санаа зовох, сэтгэл шимшрэх), **зүрх мэгших** (дотроо уйлах), **зүрх үхэх** (шантрах, бэрхшээх, халирах), **зүрх нь чичрэх** (айн хэлмэх), **зүрхээ авах** (ихэд айснаас болж хожим бэрхшээх), **зүрхээ зүсүүлэх** (ихэд айснаас халгамтгай болох), **зүрхэнд шар ус хуруулах** (өшил хясал төрөх), **зүрхэнд орох** (хашрах, айн болгоомжлох) **зүрхээ авхуулах** (юмнаас халширдаг, айж эмээдэг болох) гэх мэт байна. “Зүрх” гэдэг нь физиологийн утгаараа булчинлаг эрхтэн буюу цус шахдаг эрхтэн, монгол хэлний хэлцийн түвшинд **сэтгэл, сэтгэлийн төв**, **“дотоод сэтгэл”** гэх утгаар өргөн хэрэглэгддэг. Эдгээр хэлц нь бидний бие, эрхтэнд тохиож буй янз бүрийн мэдрэмжийг, бие махбод буюу саванд илрэх зүйрлэлээр дамжуулан илэрхийлдэг.

Өөрөөр хэлбэл, сав зүйрлэл нь сэрэл, мэдрэмжийн хийсвэр ойлголтыг физик объектоор төсөөлөн хэлцээр илэрхийлж буй танин мэдэхүйн арга болохыг мөн дараах схемээс харж болно. Жишээ:

Хүснэгт 3

Хэлц	Танин мэдэхүйн сав, багтаамжийн дүрс	Тайлбар
Зүрх өвдөх	Сэтгэл доторх саванд “өвчин” орж, дотоод догдлол үүсэх	Сэтгэл гүнзгий зовж, дотор нь харуусал, эмзэглэл мэдрэх
Зүрх шимшрэх	Савны бүтэц нь гэмтэж, дотооддоо барзгар мэдрэмжид автах	Сэтгэл эмзэглээд бэртэж, гүн гашуун мэдрэмж төрөх
Зүрхээ зүсэх	Савны бүрхүүл гэмтэж, дотоодын айдас, шаналал илэрхийлэх	Ихэд айсан, халшрах, сэтгэлийн хүч сулрах зэрэг байдлыг илтгэнэ

Эдгээр хэлц нь, хүний зүрх сэтгэл бол хийсвэр ойлголтыг тусгагч сав гэж, түүний дотор нуугдсан айдас, гашуудал, эмзэглэл зэрэг мэдрэмжүүдийг физик нөхцөл байдалтай адилтган, зүйрлэлээр илэрхийлжээ.

Судалгааны үр дүнг тодруулах үүднээс англи хэлний ойролцоо хэлцтэй харьцуулж үзвэл англи хэлэнд “heart”, “mind”, “soul” гэх үгс “сэтгэл”-ийн хэсэг утгуудыг тус тусад нь илэрхийлдэг байна. Жишээ нь:

“My heart is broken”. (сэтгэл өвдөх)

“She has a kind heart”. (сэтгэл сайтай)

“I lost my mind”. (ухаан алдах, сэтгэл тавихгүй байх)гэх мэт. Харин монгол хэлний

“сэтгэл” нь “зүрх”, “ухаан”, “оюун”, “хүсэл” гэсэн эдгээр хийсвэр ойлголтыг бүгдийг хамруулж, өөртөө багтаасан танин мэдэхүйн концепт буюу цогц ойлголт юм. Энэ нь монгол хүний сэтгэлгээ илүү бүхэллэг, синкретик шинжтэй болохыг харуулна.

Ийнхүү монгол хэлний *айдас, баяр, гуниг, гомдол, аз жаргал, хайр дурлал, зовлон бэрхшээл, уур бухимдал, итгэл найдвар* гэх мэт хийсвэр ойлголтыг сав зүйрлэлээр илэрхийлэх боломжтойг хэлцийн сангаас шинжлэн үзэж уг судалгааг үргэлжлүүлэх бүрэн боломжтой байна.

Судалгааны үр дүн

Монгол хэлний хэлц үгийн сав, багтаамжийн зүйрлэл нь байгаль, амьдралын туршлагыг илүү дэлгэрэнгүй, амьд мэтээр төсөөлж, сэтгэл хөдлөлийн орон зайг гүнзгийрүүлэн харуулдаг. Англи хэлний хэлц үг нь үйл ажиллагаа, ажил хэрэгч ойлголтод суурилсан илэрхийлэл давамгайлж, шууд утгаар ойлгогдох хандлагатай.

Монгол, англи хэлний оршихуйн зүйрлэлүүд хоёулаа хүний туршлагад тулгуурладаг ч **сэтгэлгээний чиг баримжаа ялгаатай**. Энэ нь хоёр хэлний **соёл, амьдралын хэв маяг, философийн суурь** ойлголтын ялгаатай байдлаас шууд шалтгаалж байна.

Монгол хэлэнд оршихуйн зүйрлэл нь **дотоод, натурал, бүхэллэг** шинжтэй байхад англи хэлэнд **үйл явц, бүтэц, хэсэгчилсэн** шинж давамгайлдаг.

Монгол хэлний хэлцүүдэд илрэх оршихуйн зүйрлэл нь **сэтгэл, бодол, амьдрал, цаг хугацаа, хайр, үхэл** зэрэг хийсвэр ойлголтыг **амьтай, хөдөлгөөнтэй, материаллаг** шинжээр бүтэцжүүлдэг.

Хоёр хэлэнд нийтлэг оршихуйн зүйрлэл (гал, ус, зам, сав, гэрэл гэх мэт) илэрдэг боловч, **монгол хэлэнд илүү “дотоод орон зай” (internal space) төвтэй**, **англи хэлнийх илүү “үйл явц ба объект” төвтэй** байдаг. Энэ нь **соёлын ялгаа** (нүүдэлчин орон зайн сэтгэхүй, дуалист логик) болон **туршлагын хүрээний ялгаанаас** шалтгаалж байна.

Хоёр хэлний танин мэдэхүйн сэтгэлгээний ялгаа нь ертөнцийг үзэх үзлийн зөрүүтэй байдлаар илэрч байна. Тухайлбал: монгол хүн “сэтгэл дүүрэх”-ийг **дотоод орон зайн хөдөлгөөн** гэж үздэг бол, англи хүн “to be happy” буюу **байдал, төлөв** гэж ойлгодог ажээ.

Энэхүү өгүүлэлд танин мэдэхүйн хэл шинжлэлийн зүйрлэлийн онолд тулгуурлан англи болон монгол хэлний хэлц үгсийн хүрээнд оршихуйн зүйрлэл, сав багтаамжийн зүйрлэл

хэрхэн илэрч байгааг харьцуулж үзлээ. Сэтгэл, уур, оюун ухаан зэрэг хийсвэр ойлголтыг сав мэтээр дүрслэх арга нь хоёр хэлэнд ижил байдлаар илэрдэг ч хэл зүйн болон соёлын ялгаатай хэлбэрүүд илэрч байна. Тодруулбал, монгол хэлэнд "**сэтгэлээ онгойлгох**" хэлц нь сэтгэл гэх савны хаалгыг нээхтэй адил, дотоод ертөнцөө бусдад илэрхийлэх явцыг илэрхийлж байхад "**уур нь дэлбэрэх**" гэдэг хэлцийн хувьд хүний тэвчээр хэтэрч, дотоод даралттай шингэнтэй сав хагарч байгаа мэт дүрслэлээр зүйрлэн илэрхийлсэн байна.

Ийм зүйрлэлүүд нь хүний сэтгэл зүйн үйл явцыг амьд, дүрслэлтэй, ойлгомжтой хэлбэрээр дамжуулах үүрэг зорилготой. Өөрөөр хэлбэл, монгол хэлний сав, багтаамжийн зүйрлэлээр дамжуулан хүний сэтгэл зүйг **"дотоод орон зайн"** үйл ажиллагаа байдлаар илэрхийлдэг байна. Иймд бид өөрсдийн ашигласан судалгааны хэрэглэгдэхүүнд ажиглалт хийсний үр дүнд монгол хэлний оршихуйн зүйрлэл бол **дотоод сэтгэл–байгаль–оршихуйн уялдаа** холбоон дээр тулгуурладаг гэж үзлээ. Танин мэдэхүйн зүйрлэлийн онолын хүрээнд сав багтаамжийн зүйрлэлийн үүднээс үзвэл, монгол хүний сэтгэхүйд **сэтгэл** бол зөвхөн мэдрэмж биш, **оюун ухаан, ёс суртахуун, зөн совин, амьдралын эрч хүч** бүгдийг багтаасан **нэгэн цогц ойлголт буюу концепт** юм гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Мөн монгол хэлц дэх оршихуйн зүйрлэл, сав зүйрлэлийн жишээнүүдийг ажиглахад монгол хүний сэтгэлгээ илүү бүхэллэг, нэгдмэл (синкретик) шинжтэй гэж үзэж болохоор байна.

Ашигласан ном зүй

Баянсан 2016: *Баянсан Ж.* Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ (Нэмж зассан 2 дахь хэвлэл). Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр (Анхны хэвлэл 2002), 2016.

Лакофф Ж. & Жонсон М. 1980: *Metaphors We Live By.* Chicago: University of Chicago Press, 1980.

Лакофф Ж. 1993: The contemporary theory of metaphor. In: A. Ortony (ed.). Metaphor and thought. Cambridge: Cambridge University Press, 1993.

Магсар 2012: *Магсар Ц.* Цаг үе ба метафорчлах сэтгэлгээ. "Лавай" МУБИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. № 3. Улаанбаатар, 2012.

Нансалмаа 2014: *Нансалмаа Н., Долгор С.* Танин мэдэхүйн хэл шинжлэл. Улаанбаатар: Соёмбо притинг, 2014.

Монгол хэлний цахим тайлбар толь. URL (https://mongoltoli.mn/dictionary/detail/82458).

THE MANIFESTATION OF ONTOLOGICAL METAPHOR IN MONGOLIAN IDIOMS

Sanjperleegiin Enkhjargal

Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences

Language is a reflection of human cognition and a structure of thought. In modern linguistics, analyzing idiomatic expressions from a cognitive perspective has become a common and unified approach among scholars. Idioms represent a people's worldview and patterns of thinking, expressing abstract concepts through tangible, experiential imagery. The core mechanism underlying the figurative meaning of idioms is metaphor, which is intrinsically linked to the deep structure of human cognition. Within the framework of cognitive linguistics, a "container metaphor" is regarded as a universal conceptual model derived from bodily experience and spatial perception. The paper examines how the container metaphor manifests in Mongolian idiomatic expressions, analyzing their structure and semantic features based on the metaphor theory proposed by G. Lakoff and M. Johnson, and compares selected Mongolian idioms with their English equivalents. The findings reveal that Mongolian mentality tends to be holistic and integrative, reflecting a worldview grounded in spatial and experiential understanding.

Key words: idiom, ontology, ontological metaphor, container metaphor, Mongolian mentality.

About the author: **Sanjperleegiin Enkhjargal**, Ph.D., Curator of the Phonological Library. Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences (Ulaanbaatar, Mongolia) (enkhjargals@mas.ac.mn).

ПРОЯВЛЕНИЕ ОНТОЛОГИЧЕСКОЙ МЕТАФОРЫ ВО ФРАЗЕОЛОГИЧЕСКИХ ЕДИНИЦАХ МОНГОЛЬСКОГО ЯЗЫКА

Санжпэрлээгийн Энхжаргал
Институт языка и литературы Монгольской академии наук

Язык является отражением человеческого мышления и и представляет собой систему фонетических, лексических и грамматических средств, которая служит средством выражения мыслей, чувств, волеизъявлений и общения людей. В современной лингвистике анализ фразеологических единиц с когнитивной точки зрения стал распространенным и общепринятым подходом среди исследователей. Фразеологизмы выражают мировоззрение и ментальные особенности народа, передавая абстрактные понятия через конкретные, чувственно воспринимаемые образы. Основным механизмом формирования переносного значения фразеологических единиц является метафора, неразрывно связанная с глубинной структурой человеческого сознания. В рамках когнитивной лингвистики «метафора контейнера» рассматривается как универсальная когнитивная модель, основанная на телесном опыте и пространственном восприятии человека. В данной статье исследуется, как метафора контейнера проявляется во фразеологических единицах монгольского языка; анализируются их структура и семантические особенности на основе теории метафоры, предложенной Дж. Лакоффом и М. Джонсоном, а также проводится сопоставление некоторых монгольских фразеологизмов с их английскими эквивалентами. Результаты исследования показывают, что монгольский менталитет отличается целостностью и интегративностью, отражая мировосприятие, основанное на пространственном и чувственном опыте.

Ключевые слова: фразеологизм, онтология, онтологическая метафора, метафора контейнера, монгольский менталитет.

Об авторе: **Санжпэрлээгийн Энхжаргал**, Ph. D., хранитель фонологической библиотеки, Институт языка и литературы Монгольской Академии наук (Монголия, Улан-Батор) (enkhjargals@mas.ac.mn).